БАТЛАВ
"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ОЮУНБОЛД

# "АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ"-ИЙН НЭМЭЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 06 сарын 19-ны өдөр № АД 2026/01 Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **1. Төсөл боловсруулах үндэслэл:** | • Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2026-2027 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө |
| **2. Төслийг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд:** | • Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дах заалт,<br>• Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам; |
| **3. Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил, бүрдэл:** | • Авто замын норм нормативын сангийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын үе шатны тайлан;<br>• Өгөгдлийн сангийн бүтэц (товч загвар) боловсруулах;<br>• Системийн одоогийн техникийн болон функциональ байдлыг бүрэн шалгаж, сул талуудыг илрүүлэх /аюулгүй байдал, ачаалал даах чадвар/<br>• Мэдээллийн санг бусад төрийн байгууллагын системтэй холбох /Зам тээврийн яам, Стандарт хэмжил зүйн газар/<br>• Авто замын салбарын норм нормативын баримт бичгийг:<br>- Нэгдсэн ангилал, кодчилолтой болгох;<br>- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон хүчингүй болсон норм дүрэм стандартыг ил тод болгох;<br>• Авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалт, зураг төслийн ажилд ашиглагдаж буй норм дүрэм, техникийн баримт бичиг, аргачлал, гарын авлагыг системд оруулж нэгдсэн цахим сан үүсгэх;<br>• Баримт бичгийн төрлөөр ангилах; |

- Авто замын барилгын норм /ЗЗБНбД, БНбД/
- Засвар арчлалтын норм, гарын авлага
- Гүүр, хоолойн норм, аргачлал, гарын авлага г.м

- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрэм техникийн баримт бичгийг цахим системээр худалдан борлуулах, хавсралт файлыг татахгүйгээр нээж харах байдлаар оруулах;
- Төрийн сангийн холбогдох дансыг системтэй холбох;
- Хувь хүн, аж ахуй нэгж байгууллага шинээр бүртгүүлэх, худалдан авах норм дүрмийн процессыг алхам алхмаар харуулах;
- Авто замын норм нормативын сангийн функц
  - Төлөвлөгөө
  - Тайлан
  - Тушаал, дүрэм журам
- Мэргэжлийн зөвлөл

**4. Төслийн эцсийн үр дүн:**

- Авто замын норм нормативын сангийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтыг гүйцэтгэсэн байна.

**5. Төсөл хэрэгжүүлэх хугацаа:**

- 6 сар /Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш/

**6. Төслийн тайлангийн үе шат:**

- Үе шат нь: - Эхлэл
  - Дунд
  - Эцсийнх байх бөгөөд тайлангийн хавсралтаар ажлын даалгаврын биелэлтийг гарган боловсруулсан байх;

**7. Төсөл хэрэгжих байгууллага:**

- Тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөх баг болон хуулийн этгээд /сонгон шалгаруулалтаар/ байна.

**8. Төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ:**

- Авто замын норм нормативын сан
- 20.0 сая төгрөг

**9. Гүйцэтгэх багт тавигдах шаардлага:**

- Программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллага
- Программ хангамж хөгжүүлэгч (Full-stack, DevOps), UI/UX дизайнер, мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн
- Цахим системийн хөгжүүлэлт, боловсруулалтыг гүйцэтгэж үйлчилгээ эрхэлж байсан туршлагатай байх

**10. Төслийн онцгой нөхцөл:**

- Авто замын тухай хууль болон бусад хууль дүрэм журам, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм журамд нийцүүлэн боловсруулалтыг гүйцэтгэх.
- Системийн дата өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг дангаар хариуцах.
- Хуучин программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хариуцах.
- Шинэ хөгжүүлэлтийн нэвтрүүлэлт, аюулгүй ажиллагааг бүрэн хангах.
- Төсөл хэрэгжүүлэх шатанд Захиалагч байгууллагад үе шаттайгаар мэдээлэл, танилцуулгыг зохион байгуулах.
- Төслийн хүрээнд боловсруулсан болон ашигласан бүхий л баримт бичиг холбогдох материалыг PDF файл /CD/ болон хэвлэмэл байдлаар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгнө;
- Төслийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрхийн тухай” хуулийн 19.1, 19.2, 19.5 дугаар зүйл, Оюуны өмчийн тухай хуулийн 7.2, 7.3 дахь зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн өмч болно;

**ХЯНАСАН:**

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Э.БАЛТ

**БОЛОВСРУУЛСАН:**

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн — Т.БАТБОЛД

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн — О.ДОЛГИОН